



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г.корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: [ub@audit.gov.mn](mailto:ub@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР  
ДЭВШИХ ИРГЭН Г.ОТГОНРАГЧАА  
ТАНАА**

2020. 08. 31 № 1330

таний -ны № -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дэвшиг Төрийн аудитын байгууллагын бүрөн орхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сэлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Гомбын Отгонрагчаагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

## Дүгнэлт

Иргэн Гомбын Отгонрагчаагийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Гомбын Отгонрагчаагийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (З. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хан-Уул дүүргийн Сонгуулийн хороонд

Хавсралт: З. хуудастай.



ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮРӨРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ **Б. НОМИНБААТАР**

**ДҮҮРЭГ, НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ГОМБЫН ОТГОНРАГЧАА  
Мөрийн хөтөлбөр**

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, тулгуур зарчмыг үндэс болгон, Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сонгогч таньд танилцуулж байна.

АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 “Сум, дүүргийн хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь аймаг, нийслэлийн Хурлын Төлөөлөгчид зэрэг нэр дэвшиж болно” гэж заасныг үндэслэн Хан-Уул дүүрэг, нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчид зэрэг нэр дэвшихээ илэрхийлэн энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулав.

Мөрийн хөтөлбөрийн үзэл баримтлал: Төрт ёс, түүх уламжлал, тусгаар тогтнолоо бэхжүүлж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах, хүн амын амьдрах орчин нөхцлийг сайжруулах боллого, үйл ажиллагааг баримтлана.

Мөрийн хөтөлбөрийн үндсэн чиглэл:

**Нэг:** Орон нутгийн удирдлага, засаглалыг иргэдэд ээлтэй, экологид хөнөөлгүй байх бодлогын орчинг бүрдүүлнэ.

- 1.1. Орон нутгийн оорөө удирдах ёсны байгууллагыг чадавхжуулах, бүтэц, төсвийг үр ашигтай болгох, үрэлгэн зардлыг бууруулаха.
- 1.2. Хот, дүүргийн бүтэц, төрийн албыг зардал багатай, цомхон, чадварлаг, чирэгдэлгүй ажиллах чиг үүргийн инженерчлэл хийнэ.
- 1.3. “Байгальд ойр хот” концепциор хотын хөгжлийг загварчлана.
- 1.4. Төсвийн зардлыг ач холбогдол, үр өгөөжийн төвшингөөр эрэмбэлэх зарчимд шилжүүлж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлнэ.
- 1.5. Авиалгажсан төсвийг цэвэрлэнэ, үрэлгэн зардлыг үгүй хийнэ.
- 1.6. Нүхэн жорлон, утаат яндангүй Улсын нийслэлтэй болно.
- 1.7. Эрх мэдэлтэнд ээлтэй, иргэдэд халтай журам, шийдвэрүүдийг нэн даруй хүчингүй болгоно.
- 1.8. Хувь хүн бус хууль засагладаг тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.9. Эрх нь зөрчиглсний дария бус, зөрчигдэхөөс өмнө хамгаалах “Лиоулгүй амгалан хот” тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.10. Эрх мэдэлтний ямбыг халж, эгэл олныхоо зовлонг нимгэлнэ.

**Хоёр:** Хот, дүүргийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулж, хүн амын амьдрах орчин нөхцлийг сайжруула.

- 2.1. Дүүрэг, хороодыг хөгжүүлэх хөгжлийн нэгдсэн бодлогыг боловсруулж, төлөвлөлтийг нэг цонхоор хэрэгжүүлнэ.
- 2.1.1. Хөрсний бохирдолгүй
- 2.1.2. Хорт утаагүй
- 2.1.3. Хог хаягдалгүй
- 2.1.4. Хотын түгжрэлгүй
- 2.1.5. Хүчирхийлэл архидалтгүй хороо, дүүрэг, хотыг бий болгоно.
- 2.2. Инженерийн дэд бүтэктэй гэр хороолол гэсэн гэр хорооллын хөгжлийн бодлогыг боловсруулна. Эрх зүйн орчныг бүрдүүлэх санаачилгыг авч хэрэгжүүлнэ.
- 2.3. Гэр хороололд төвийн болон хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцийг бий болгоход шинэ дэвшилтэт, өндөр технологийг нэвтрүүлэх бодлогыг баримтална.



- 2.4. Хот Суурин Газрыг Дахин Хөгжүүлэх тухай Хуулийн 13.1.1-д заасан Төсөл санаачилах эрх бүхий иргэд “Өмч, эзэмшийн газраар хувь шийлүүлэн” хот суурин газрыг дахин хөгжүүлэх төслийг хамтран хэрэгжүүлэхээр Иргэдийн төлөөллийн байгууллага байгуулсан бол
1. Дэд бүтцийг улс, нийслэл, орон нутгийн бодлогоор дэмжих
  2. Хөрөнгийн эх үүсвэрийг Иргэдийн төлөөллийн байгууллагатай харилцан тохиролцож шийдвэрлэх үүргийг төр, орон нутгийн удирдах байгууллага хүлээдэг байх бодлогыг баримтална.
  3. Инженерийн дэд бүтэцтэй гэр хороолол буюу хаашаа хөтөлбөрийг санаачилан боловсруулна.
- 2.5. Төлөөллийн байгууллагаа байгуулж, төлөвлөлтөө хийсэн газрууд дээр дэд бүтцээ татах, амины орон сууц барих иргэдэд 20-30 жилийн хугацаатай, бага хүүтэй үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан урт хугацааны зээл /ипотек/-ийг авах нөхцлийг судалж, урт хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлэх бодлого боловсруулна.
- 2.6. Хогын цэгүүдийг түшиглэн бүсчилсэн байдлаар /Морин даваа, цагаан даваа/ шил, хуванцар, гялгар уут, цаасны хаягдлыг ангилж, дахин боловсруулах үйлдвэр барих, дотоодын хэрэгцээг хангах бодлого баримтална. Хогын дахин боловсруулах чиглэлд үйлдвэр барих иргэд, хувийн хэвшил, олон улсын байгууллагын санаачилгыг дэмжиж, хэрэгжүүлнэ. Хороо, хот, дүүргийн хотыг шинэлж ялгуулан авах журмыг баталж мөрдүүлнэ.
- 2.7. Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтэц, хот, сууринг хөгжүүлэх, дахин төлөвлөх, түргэн барих технологийг нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.7.1. Энэ хүрээнд хуучирсан орон сууцуудын фасад дулаалга, сан техникийн шинэчлэлийг үе шаттайгаар шийдвэрлэх хот, дүүргийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 2.8. Хот, дүүргийн замын ачаалал, түгжрэлийн бууруулах ажлыг эрчимжүүлнэ. Соронзон замын Monorial нийтийн тээврийг нэвтрүүлэх бодлогыг баримтална.
- 2.9. Аюулгүй, цэвэр, тохилог, ногоон хотыг бий болгох “Ногоон бүс” хөтөлбөрийг санаачилна.
- 2.9.1. Цэцэрлэг, сургууль, эмнэлэгийн орчны бүсийн 500-1000 метрийн тойрогт эко ногоон орчин, камериийн хяналт бүхий хүүхэд, эмчлүүлэгчдэд ээлтэй “Аюулгүйн бүс”-ийг бий болгох хөтөлбөр, журмыг боловсруулна.
- 2.10. Архидалт, хүчирхийллийн эсрэг аян, хөтөлбөрийг хороо, дүүрэг бүрт хэрэгжүүлэх нэгдсэн бодлогыг боловсруулна.
- 2.10.1. Архи, согтууруулах ундаа үйлдвэрлэгч, борлуулагч, түүгээр үйлчлэгч байгууллагын татварын орлогын 3-5 хувийг “Архидалт, хүчирхийллийн эсрэг сан”-д төвлөрүүлэн “Эрүүл, энэрэнгүй амьдрах төв”-үүдийг байгуулах бодлого, үйл ажиллагааг дэмжинэ.
- 2.11. Түрээсийн болон урт хугацааны бага хүүтэй зээлийн эх үүсвэрээр орон сууцжуулах улс, хот, дүүргийн баримталж буй бодлогыг олон улсын түргэн барих технологийг нэвтрүүлэх аргаар богино хугацаанд хэрэгжүүлэх боломжийг нээнэ.

**Гурав.** Байгаль хамгаалал, хүрээлэн буй орчин

- 3.1. Байгалияа хамгаалах, хүрээлэн буй орчноо ногооруулах, сэргээн тохижуулах хот, дүүргийн бодлогыг уялдуулж, нэгдсэн төлөвлөлт, хөтөлбөртэй болгоно.
- 3.2. Туул голын сав, суурьшлын бүс дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалыг олборлох, тээвэрлэх, нөхөн сэргээхтэй холбоотой асуудлыг журам боловсруулж цэгцэнэ.
- 3.3. Гол ус, булаг, шандны урсацыг сэргээх, хамгаалах, ногоон байгууламжжуулах нэгдсэн бодлоготой болгоно.
- 3.4. Эрчим хүчний байгальд ээлтэй эх үүсвэрүүдийг ашиглах, хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлийг бодлогоор урт хугацаанд дэмжиж ажиллана.



- 3.5. Байгаль орчинд сөрөг нолоө үзүүлж буй үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудын стандартыг нарийвчлан тогтоож мөрдүүлнэ.
- 3.6. Түүх, соёлын дурсгалт болон эко системийн тэнцвэрийг хадгалах газар нутгийг Орон нутгийн тусгай хамгаалалтад авч, сэргээн хөгжүүлэх бодлогыг баримтална.
- 3.7. Орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах бодлогыг бүрдүүлнэ.

**Дөрөв.** Өрхинн орлого, үйлдвэрлэл, хот, дүүргийн хөгжил

- 4.1. Амьдралын баталгаатай дундаж давхаргыг бий болгох “Хүн төвтэй хот” бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.2. Баялаг бүтээгчдээ эдийн засгийн бодлогоор дэмжинэ.
- 4.3. Орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх өрхийн аж ахуйг хот, дүүргийн түвшинд дэмжинэ.
- 4.4. Мэдлэг, инноваци, өндөр технологийн судалгаа, хөгжүүлэлтийн сан бий болгох, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогыг баримтална.
- 4.5. Нийслэлд үйлдвэрлэгдсэн Үндэсний бүтээгдэхүүнийг Хот, дүүргийн удирдлага болон өмчид хамаарах бүх байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжүүд худалдан авалт хийх байдлаар үндэсний Үйлдвэрлэл, өрхийн бизнесийг дэмжих “Үйлдвэрлэгчдээ дэмжье” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.  
Үндэсний бүтээгдэхүүний түриэн эрээгийн нэмэгдүүлийнэ.
- 4.5.1. Уг хотолборийг дэмжигч хувийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг татварын хөнгөлөлт, урамшууллын нэгдсэн сүлжээгээр дэмжинэ.
- 4.6. Туул голын сав газрыг түшиглэн иргэд, залуучуудад зориулсан усан парк, соёл амралтын бүс байгуулах хот, дүүргийн санаачилгыг дэмжиж ажиллана.
- 4.7. Ахмад настан, хүүхэд баагчууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусай тоноглол бүхий спорт цогцолбор, цэцэрлэгт хүрээлэн байгуулах хот, дүүргийн санаачилгыг дэмжинэ.

**Тав.** Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол

- 5.1. Ажил эрхлэлтийг дэмжих тогтвортой, ажлын байрыг нэмэгдүүлэх олон тулгуурт бодлогыг боловсруулж, эдийн засгаа хөгжүүлэх, иргэдийнхээ амьдралыг сайжруулах ёсөлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 5.2. Хөдөлмөр, нийгмийн халамжийн хэлтэс, мэргэжлийн сургалтын төв, ажил олгогч гэсэн гувалсан тогтолцоог бий болгож ажлын байртай шууд холbon тогтвортой ажил эрхлэх бодлого баримталж, ажилийн үйдлийг бууруулах хөтөлбөрийг эхлүүлнэ.
- 5.3. Сэтгэлийн боловсрол, цахим сургалтын нэгдсэн платформыг бий болгох санаачлагыг дэмжинэ.
- 5.4. Багш, эмч, цэргийн болон цагдаа, төрийн алба хаагчдын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх бодлогыг баримтална. Төрийн алба хаагчид, ахмадууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөрийг эрчимжүүлнэ.
- 5.5. Нийгмийн даатгалыг урьдчилгаа болгон барьцаалах хэлбэрээр 4-6 хувийн хүүтэй ипотекийн зээлээр хямд үнэтэй орон сууцанл орох эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Мөн өрхийн бизнесийг дэмжих зээлийн эх үүсвэрийг бий болгох бололцоог судална.
- 5.6. Сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн хүртээмж, үйлчилгээний чадавхийг нэмэгдүүлэх, цэцэрлэгийн орох, тараах цагийг сунгаж, багшинн орон тоог 2 болгох, хүүхдийн автобусны хүрэлцээг нэмэгдүүлэхэд онцгой анхаарна.
- 5.7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ойртуулна.
- 5.8. Иргэдээ эрүүл, аюулгүй, тохилог орчинд амьдруулах олон улсын өндөр технологийн бүтээгдэхүүнийг гадаад хамтын ажиллагааны хүрээнд нэвтрүүлнэ.

МОРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛСАН

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН

Г.ОТГОНРАГЧАА



1117145633  
УХА0612 9077278